



Хүндэт Эцэг эх/Асран хамгаалагч танаа:

Та болон таны гэр бүл зуу гаруй гадаад хэлээр ярьдаг, олон янзын соёл зэрэгцэн оршдог хамт олны гишүүд болсон явдалд бид талархаж байна. Prince William гүнлэгийн улсын сургуулиуд нь сурагч бүрт *Дэлхийн Хэмжээний Боловсрол* эзэмшүүлэхийг зорьж ажилладаг. Сургалтын явцад гэр бүлийн түншлэл чухал үүрэгтэй бөгөөд бид хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нарт хүүхдийн боловсролд оролцох, ойлголттой болоход нь дөхөм болох зарим үндсэн мэдээллийг хүргэж байгаадаа баяртай байна.

Сургуулийн бүх материалыг Англи хэлээр боловсруулсан хэдий ч бид үндсэн бичиг баримт, мэдээллийг манай бүсэд хамгийн өргөн хэрэглэгддэг гадаад хэлнүүд рүү тасралтгүй хөрвүүлж байдаг.

Ихэнх гадаад хэлээр яригчид Prince William гүнлэгийн улсын сургуулиудын веб хуудас болох pwcs.edu болон сургуулийн хувийн веб хуудаснуудаас чухал агуулгатай, тогтмол шинэчлэгддэг мэдээллийг авч үзэж болно. Мэдээллийг нэр бүхий Google орчуулгын хэрэгсэлтэй холбосон байх ба энэ нь 50 гаруй хэлээр бүрэн бус орчуулга хийх чадвартай юм. Компьютерын орчуулга ихэвчлэн төгс бус байдаг ч сургуулийн талаарх чухал мэдээллийг хүргэхэд дөхөмтэй байх болно. Та гэртээ компьютергүй бол ямар ч нийтийн номын сангийн компьютерыг ашиглаж болно.

Сургуулийн Хэлтэс нь сурагч болон эцэг эхчүүдийн эрх, үүрэг, хариуцлага, ирээдүйн төлөв болон хичээлтэй холбоотой бусад асуудал, тусламж ба үйлчилгээний талаарх чухал мэдээлэл бүхий бичиг баримтуудыг ойлгох явдалд туслах зорилгоор ихэнх гадаад хэл эзэмшигчдийг мэргэжлийн орчуулагч нартай холбож өгнө. Орчуулагчид мөн дээрх асуудлаар зохион байгуулагдах эцэг эхийн хуралд хэлмэрчилж, хүн бүрийн оролцоог хангах ба бүрэн ойлголт авах явдлыг баталгаажуулна. Эдгээр үйлчилгээг авахад тухайн өрх, гэр бүлээс ямар нэг зардал гарахгүй.

Дараах аргуудын аль нэгийг ашиглан шаардлагатай туслалцааг авна уу:

- Онлайн - translations.pwcs.edu хаягаар орно уу

- Биечлэн уулзах – хүүхдийнхээ сургууль дээр очих. Таны төрөлх хэлээр ярьдаг хүн тухайн үед олохгүй байх магадлалтай. Гэхдээ манай ажилтан танд туслахын тулд зурагт хуудас ашиглах болно.

Аль ч тохиолдолд танаас дараах мэдээллийг хүсэх болно:

- Таны болон таны хүүхдийн нэр;
 - Таны хүүхдийн сургууль, анги ба багшийн нэр;
 - Таны уулзахыг хүссэн хүн (нэр эсвэл албан тушаал) болон ярианы сэдэв; мөн
 - Тантай холбоо барих утасны дугаар ба боломжтой цаг.
- Хэрэв таныг сургууль дээр ирж уулзахыг хүүхдээр тань дамжуулж мэдэгдсэн, эсвэл та өөрөө багш эсвэл сургуулийн бусад албан тушаалтантай уулзахыг хүссэн тохиолдолд дээр дурьдсан аргуудыг ашиглан, чухал яриаг өрнүүлэхэд шаардлагатай орчуулагчийн туслалцааг авна уу. Хэн нэгэн тантай аль болох түргэн холбогдох болно.

Таны оролцоо хүүхдийн тань боловсролд эерэг өөрчлөлт оруулж чадах ба бид дээрх үйлчилгээг танд хүргэхээр идэвхийлэн ажиллах байна. Prince William гүнлэгийн улсын сургуулиудын зүгээс та болон таны хүүхдийн өмнө хүлээх үүрэг, амлалтын талаар энэхүү захидал тодорхой мэдээлэл өгөх болно гэж бид найдаж байна. Сурагч бүрт Дэлхийн Хэмжээний Боловсрол эзэмшүүлэх бидний эрмэлзлийг та хуваалцаж байгаа гэдэгт итгэлтэй байна.

Хүндэтгэсэн,



Dr. Steven Walts

Сургуулиудын эрхлэгч

*pwcs.edu веб хуудсаар зочлохдоо, энэхүү захидалд дурдсан мэдээлэлтэй хуудсуудыг олохын тулд дэлхийн бөмбөрцгийн өнгөт дүрсийг хай.

